


# ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР

## ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 2230 эх төрсөн нь өмнөх оны мөн үеэс 57 төрөлтөөр буюу 2.5 хувиар буурсан. Төрсөн эхчүүдийн 1365 нь буюу 61.2 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан. Нийт төрөлтийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа бөгөөд улсын үзүүлэлттэй адил байна. Төрсөн эхчүүдийн 860 буюу 38.6 хувь нь төрөлтийн хүндрэлтэй төрсөн.

Төрөлт Орхон аймаг 2016-2023 он



2023 онд эхийн эндэгдэл бүртгэгдээгүй бол улсын хэмжээнд 17 тохиолдол буюу 100000 амьд төрөлтөд 26.4 промилл байна.

Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 2016-2023 он



Нийт төрсөн эхчүүдийн 501 /22.5%/ анх төрсөн, 594 /26.6%/ хоёр дахь төрөлт, 649 /29.1%/ гурав дахь төрөлт, 343 /15.4%/ дөрөв дэх төрөлт, 106 /4.7%/ тав дахь төрөлт, 37 /1.6%/ зургаагаас дээш удаа төрсөн байна.

### Төрөлтийн давтамж

1	-	501	-	22.5%
2	-	594	-	26.6%
3	-	649	-	29.1%
4	-	343	-	15.4%
5	-	106	-	4.8%
6	-	28	-	1.3%
7	-	4	-	0.2%
8	-	3	-	0.1%
9	-	2	-	0.1%

Нийт дүн = 2230

### ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ БА ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

ДЭМБ-аас жирэмсэн үеийн хяналтад наад зах нь найман удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгосон ба цусны даралт хэмжих, шээсэнд бактери, уураг илрүүлэх шинжилгээ, тэмбүү болон хүнд хэлбэрийн цус багадалтыг илрүүлэх цусны шинжилгээ, жин/өндрийн хэмжилт зэрэг тусгайлсан үйлчилгээг зөвлөмж болгодог. Манай улсад хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг 6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг бөгөөд эх жирэмсэн болсноо мэдмэгц 12 долоо хоногоос дотогш хугацаанд эхний үзлэгт хамрагдахыг шаарддаг.

2023 оны жилийн эцсийн байдлаар жирэмсний хяналтад шинээр 1562 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 98.5 хувь нь эхний 3 сартайд, 1.4 хувь нь 4-6 сартайд, 0.1 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад хамрагджээ. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.9 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 5.3 хувь нь цус багадалттай байна.

#### Жирэмсний хяналт 2018-2023

Он	Жирэмсний хяналтад шинээр орсон	Эхний 3 сартайд		4-6 сартайд	7 ба түүнээс дээш сартайд	Цус багадалттай жирэмсэн	
		Тоо	Хувь			Орхон	Улс
2018	2018	Тоо	1839	175	4	40	3.4
		Хувь	91.13	8.67	0.20	1.98	
2019	2022	Тоо	1899	117	6	35	3.5
		Хувь	93.92	5.79	0.30	1.73	
2020	1870	Тоо	1776	92	2	39	
		Хувь	95.0	4.9	0.1	2.1	3.6
2021	1636	Тоо	1583	51	2	27	4.0
		Хувь	96.7	3.1	0.1	1.6	
2022	1680	Тоо	1620	57	3	23	4.4
		Хувь	96.4	3.4	0.2	1.4	
2023	1562	Тоо	1538	22	2	83	
		Хувь	98.5	1.4	0.1	5.3	3.9

### Жирэмсний хяналт өрхийн эрүүл мэндийн төвүүдээр 2022-2023 он

№	Эмэгтэйн нэр	Нэгт шинжлэлт хамрагдсан эмэгтэйнүүд		Хяналтад авсан хувь						6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж төрсөн (хувиар)			Цус багдалттай жирэмсэн эмэгтэйнүүд (хувиар)		
		2022	2023	Эхний 3 сартайд		Өмнөх оны мөн үеэс	4-6 сартайд		7 ба түүнээс дээш сартайд		2022	2023	Өөрчлөлт	2022	2023
				2022	2023		2022	2023	2022	2023					
1	Үйлс Базрын	161	120	95.4	98.3	+1.1	0.6	1.7		61.0	65.7	+4.7		1.7	
2	Нийцэл	220	197	96.2	97.0	+1.2	1.4	3.0	0.4	57.8	63.5	+5.7	1.8	8.6	
3	Мөнхийн газар	93	114	100	98.2	-1.8		1.8	1.8	64.5	55.5	-9.0			
4	Энхжилмандариваа	194	153	97.9	98.0	+0.1	1.5	2.0	0.5	50.8	67.2	+16.4	0.5	5.9	
5	Аюуль он	337	340	93.2	95.7	+2.5	6.8	0.3		57.0	58.5	+1.5	3.9	1.5	
6	Монголжин	297	283	95.9	99.3	+3.4	4.1	0.7		63.7	67.1	+3.4	0.7	4.2	
7	Учралбар	732	706	95.7	99.0	+3.3	4.8	1.0		54.4	57.8	+3.4	0.9	4.9	
8	Мөнхсүндэрэл	119	118	95.8	96.6	+0.8	3.4	3.4	0.8	55.4	55.1	-0.3		24.1	
9	Жаргалант	27	33	100	93.9	-6.1		6.1		53.7	63.2	+9.5	3.7		
	<b>Аймагийн дүн</b>	<b>1680</b>	<b>1582</b>	<b>96.4</b>	<b>98.3</b>	<b>+2.1</b>	<b>3.4</b>	<b>1.4</b>	<b>0.2</b>	<b>58.0</b>	<b>61.2</b>	<b>+3.2</b>	<b>1.4</b>	<b>5.3</b>	

Цус багдалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Мөнхсүндэрэл, Нийцэл, Энхжилмандариваа өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр огцом өссөн байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүд тэмбүү илрүүлэх шинжилгээнд 99.9 хувь хамрагдсанаас 0.6 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 0.6 хувиар буурсан. Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүд 99.9 хувь хамрагдаж 0.06 хувьд эерэг илэрсэн. Трихомониаз илрүүлэх шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 1.9 хувьд нь трихомониаз өвчин илэрч өмнөх оноос 0.5 хувиар өссөн байна. 2023 онд аймгийн хэмжээнд төрөлхийн тэмбүүгийн 1 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн онтой адил байна.

### Жирэмсний хяналт /Орхон аймаг 2016-2023 он/



Жирэмсний хяналт 2023, хувиар

№	Аймаг/хот	Хяналтад авсан хувь			6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж төрсөн	Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүд
		Эхний 3 сартайд	4-6 сартайд	7 ба түүнээс дээш сартайд		
А	Б	1	2	3	4	5
1	Архангай	88.5	10.2	1.4	79.6	2.7
2	Баян-Өлгий	93.1	6.8	0.2	72.0	8.9
3	Баянхонгор	92.0	7.0	1.0	93.1	3.0
4	Булган	95.1	4.5	0.4	78.9	1.1
5	Говь-Алтай	94.0	5.9	0.1	80.0	1.0
6	Говьсүмбэр	92.8	6.1	1.1	90.0	5.7
7	Дархан-Уул	96.7	3.2	0.2	77.9	13.1
8	Дорноговь	91.0	7.7	1.2	85.8	2.4
9	Дорнод	94.1	5.7	0.2	84.2	2.2
10	Дундговь	91.3	7.7	0.9	92.2	0.5
11	Завхан	93.1	6.7	0.2	85.8	2.6
12	Орхон	98.5	1.4	0.1	61.2	5.3
13	Өвөрхангай	93.0	6.3	0.7	72.5	2.7
14	Өмнөговь	89.9	9.0	1.1	96.1	1.5
15	Сүхбаатар	88.4	10.8	0.8	97.0	2.0
16	Сэлэнгэ	89.9	9.0	1.0	87.9	1.0
17	Төв	92.6	6.9	0.5	91.3	1.9
18	Увс	96.6	3.1	0.3	63.4	2.2
19	Ховд	93.3	6.2	0.5	93.2	6.8
20	Хөвсгөл	92.8	6.6	0.5	72.1	1.6
21	Хэнтий	93.2	6.2	0.6	75.1	1.5
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>93.0</b>	<b>6.5</b>	<b>0.6</b>	<b>80.1</b>	<b>3.8</b>
23	Улаанбаатар	91.6	7.5	0.9	80.8	4.1
24	<b>Улсын дундаж</b>	<b>92.2</b>	<b>7.0</b>	<b>0.8</b>	<b>80.5</b>	<b>3.9</b>

Жирэмсний эрт үеийн хяналтын улсын дундаж 92.2 хувь, 6 ба түүнээс дээш удаагийн хяналт 80.5 хувьтай байна. Жирэмсний хяналтыг улс аймгийн үзүүлэлттэй харьцуулахад эрт үеийн хяналт хамгийн өндөр аймаг боловч 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж төрсөн үзүүлэлтээр хамгийн сүүлд орж байна.

### ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭС

Аймгийн хэмжээнд 2023 онд 2230 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 57 төрөлтөөр буурсан. Гэрийн төрөлт 6 бүртгэгдсэн. 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 2234 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 75 хүүхдээр буурсан. Амьд төрсөн хүүхдийн 92 нярай буюу 4.1 хувь нь 2500 гр-аас доош жинтэй төрсөн. Төрөлхийн гажигтай төрсөн 22 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөнд 9.8 буюу өмнөх оноос 2.8 промиллоор буурсан.

Амьд төрсөн хүүхдийн тоо 2017-2023 он

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Орхон аймаг	2696	2621	2648	2555	2517	2309	2234
Улсын дүн	80875	78194	78223	76261	71658	65586	64306

Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа 2023, хувиар

№	Аймаг/хот	Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь					Төрөлхийн гажигтай төрсөн	2500 гр-аас доош жинтэй төрсөн хүүхэд
		22-28 долоо хоногтой	29-32 долоо хоногтой	33-36 долоо хоногтой	37-41 долоо хоногтой	42 долоо хоногоос дээш		
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	0.2	1.2	3.7	94.9	0.0	0.5	4.7
2	Баян-Өлгий	0.2	0.8	2.9	96.1	0.0	0.4	5.4
3	Баянхонгор	0.1	0.8	4.6	94.6	0.0	0.4	4.5
4	Булган	0.2	0.2	6.3	93.3	0.0	1.2	2.8
5	Говь-Алтай	0.2	0.5	2.2	97.0	0.0	1.0	4.4
6	Говьсүмбэр	0.3	0.6	2.0	97.1	0.0	1.7	2.9
7	Дархан-Уул	0.1	0.3	3.5	93.4	2.7	0.2	2.4
8	Дорноговь	0.6	0.3	2.6	96.3	0.3	0.5	2.5
9	Дорнод	0.1	0.3	3.2	96.4	0.0	0.9	2.8
10	Дундговь	0.6	0.6	2.5	96.4	0.0	0.9	2.7
11	Завхан	0.1	0.6	2.5	96.8	0.0	0.6	3.7
12	Орхон	0.2	0.5	3.7	95.6	0.0	1.0	4.1
13	Өвөрхангай	0.3	0.9	3.9	94.9	0.0	0.2	4.8
14	Өмнөговь	0.3	0.6	3.0	95.8	0.4	0.3	3.2
15	Сүхбаатар	0.1	1.0	3.5	95.4	0.0	0.7	3.1
16	Сэлэнгэ	0.1	0.8	2.9	96.3	0.0	0.3	3.3
17	Төв	0.1	0.4	5.3	94.1	0.1	0.4	2.4
18	Увс	0.1	0.3	3.8	95.7	0.0	0.6	3.3
19	Ховд	0.3	0.5	5.0	94.1	0.0	0.7	3.0
20	Хөвсгөл	0.2	0.7	5.1	93.8	0.2	0.9	2.9
21	Хантий	0.2	0.5	3.5	95.9	0.0	0.7	2.6
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>0.2</b>	<b>0.6</b>	<b>3.7</b>	<b>95.3</b>	<b>0.2</b>	<b>0.6</b>	<b>3.6</b>
23	Улаанбаатар	0.4	1.0	6.5	92.0	0.1	0.8	5.0
24	<b>Улсын дундаж</b>	<b>0.3</b>	<b>0.8</b>	<b>5.2</b>	<b>93.5</b>	<b>0.2</b>	<b>0.7</b>	<b>4.4</b>

Төрсөн хүүхдийн мэдээлэл / Орхон аймаг 2016-2023 он/



ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг. Манай аймгийн хувьд 2023 оны байдлаар 592 эх буюу 26.5 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар төрсөн эхийн тоог өмнөх онтой харьцуулахад 1 хувиар өссөн байна. Нийт төрсөн эхчүүдийн 1767 /79.2%/ хувь нь Орхон аймгийн харьяат, 20.8 хувь нь бусад орон нутгийн харьяатай эхчүүд төрсөн байна.

*Төрсөн тухай үзүүлэлт /Сүүлийн 7 жилээр/*



*Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 2016-2023 он*

Он	Орхон аймаг	Улсын дундаж
2016	2.6	6.2
2017	6.6	6.0
2018	4.0	5.6
2019	4.1	5.2
2020	5.1	5.4
2021	4.4	5.5
2022	4.4	5.3
2023	4.0	5.3

Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 4.0 өмнөх оноос 0.4, улсын дунджаас 1.3 промилоор бага байна.

Охидын төрөлтийн 54 тохиолдол бүртгэгдэж тухай насны 1000 эмэгтэйд 6.4 ногдож байна. Өмнөх оноос 28 тохиолдлоор буурсан. Охидын төрөлт нийт төрөлтийн 2.4 хувийг эзэлж байгаа бол 35-аас дээш насны төрөлт 22.6 хувийг эзэлж байна. Охидын төрөлтийн 13 тохиолдол харьяаллын бус иргэд төрсөн байна.

Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж 2023, хувиар

№	Аймаг/хот	Төрөлтийн эзлэх хувь					20 хурталх насны төрөлт	35-аас дээш насны төрөлт
		Аймаг, хотын нэгдсэн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Сумын нэгдсэн эмнэлэг	Сумын эмнэлэг	Гэртээ		
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	86.6	0.0	0.0	13.1	0.3	3.0	17.9
2	Баян-Өлгий	85.6	0.0	0.0	14.2	0.2	0.9	18.8
3	Баянхонгор	95.1	0.0	0.0	4.5	0.4	4.6	16.7
4	Булган	83.3	0.0	0.0	16.6	0.2	4.2	21.9
5	Говь-Алтай	95.2	0.0	0.0	4.5	0.3	5.1	19.8
6	Говьсүмбэр	99.4	0.0	0.0	0.3	0.3	5.9	22.6
7	Дархан-Уул	99.5	0.0	0.0	0.0	0.5	3.7	23.2
8	Дорноговь	90.3	0.0	8.5	1.1	0.1	4.8	21.2
9	Дорнод	97.8	0.0	0.0	1.9	0.3	3.9	24.4
10	Дундговь	94.9	0.0	0.0	5.1	0.0	4.9	17.9
11	Завхан	59.6	0.0	35.0	5.3	0.1	3.2	18.5
12	Орхон	99.6	0.0	0.0	0.1	0.3	2.4	22.6
13	Өвөрхангай	81.1	0.0	12.8	6.0	0.2	4.0	21.2
14	Өмнөговь	82.1	0.0	0.0	17.8	0.1	4.4	19.4
15	Сүхбаатар	95.7	0.0	0.0	4.0	0.3	4.2	23.4
16	Сэлэнгэ	52.6	0.0	40.4	6.7	0.3	3.4	24.2
17	Төв	84.3	0.0	0.0	15.6	0.1	4.0	26.3
18	Увс	90.7	0.0	0.0	9.0	0.2	1.8	19.5
19	Ховд	87.9	0.0	6.6	5.5	0.0	2.7	18.6
20	Хөвсгөл	87.0	0.0	0.0	12.5	0.5	5.6	18.6
21	Хэнтий	80.8	0.0	9.6	9.3	0.2	5.0	20.7
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>87.4</b>	<b>0.0</b>	<b>6.0</b>	<b>7.3</b>	<b>0.2</b>	<b>3.6</b>	<b>20.6</b>
23	Улаанбаатар	93.6	6.1	0.0	0.0	0.4	3.0	25.1
24	<b>Улсын дундаж</b>	<b>90.7</b>	<b>3.2</b>	<b>2.4</b>	<b>3.4</b>	<b>0.3</b>	<b>3.3</b>	<b>23.0</b>

**ТӨРСНИЙ ДАРААХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

2023 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 1948 тохиолдол бүртгэгдсэн.

Нийт хүндрэл дотор :

- Жирэмсэн үеийн хүндрэл – 48.1 хувь
- Төрөх үеийн хүндрэл – 38.6 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл – 0.7 хувь

*Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл 2016-2023 он*

Он	Жирэмсний хүндрэл		Төрөлтийн хүндрэл		Төрсний дараах хүндрэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
2016	630	24.2	1672	64.0	19	0.7



2017	634	24.7	1651	64.0	15	0.6
2018	716	26.2	1827	67.0	17	0.7
2019	516	19.7	1640	62.0	25	1.0
2020	642	32.9	1294	66.3	14	0.7
2021	1020	40.8	1390	55.6	23	0.9
2022	894	39.1	961	42.0	23	1.0
2023	1072	48.1	860	38.6	16	0.7

## ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГА ХЭРЭГЛЭЭ

Аймгийн хэмжээнд төрөх насны эмэгтэйчүүдийн 59.5 хувь нь буюу 1000 эмэгтэй тутмын 595.5 нь жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэсэн байна. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглээг төрлөөр нь авч үзэхэд бэлгэвч 31.3, ерөндөг 29.7, бэлдмэл /эм/ 19.6, тариа 9.8, суулгац 3.5, гуурсан хоолой боох 2.0 хувийг тус тус эзэлж байна. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж байгаад жирэмсэлсэн 15 тохиолдол бүртгэгдсэн.

*ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо оны эцсийн байдлаар 2016-2023*

	Бүгд	ЖСАХ-ийн төрлөөр						
		Бэлдмэл п./эм	Тариа	Суулгац	Бэлгэвч	Ерөндөг	Гуурсан хоолой боох	Бусад
2016	16285	3065	1817	95	6933	4095	259	21
2017	15232	2931	2135	176	5496	4203	249	42
2018	15167	3280	1754	207	5193	4517	216	
2019	15010	3230	1357	294	5396	4444	273	16
2020	15573	3123	1765	315	5325	4759	286	
2021	15577	3114	1654	469	5276	4596	325	143
2022	15458	2697	1563	570	5267	4360	324	670
2023	15422	3018	1522	533	4831	4587	321	610

## ҮР ХӨНДӨЛТ

2023 онд үр хөндөлтийн 212 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 196 тохиолдлоор буурсан, 1000 амьд төрөлтөд 94.9 промилл. Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 20-иос доош насны үр хөндөлт 11 буюу 5.2 хувьтай байна. Өмнөх онтой харьцуулахад 20-иос доош насны үр хөндөлтийн түвшин 1.3 промилоор өссөн.

Үр хөндөлтийн түвшин 2023

№	Аймаг/хот	Үр хөндөлтийн тоо			Үр хөндөлтийн харьцаа (1000 амьд төрөлтөд)		
		2022 он	2023 он	5 жилийн дундаж	2022 он	2023 он	5 жилийн дундаж
1	Архангай	202	137	249	150.5	103.8	162.3
2	Баян-Өлгий	101	147	108	36.4	54.3	37.7
3	Баянхонгор	133	84	220	79.3	52.0	118.3
4	Булган	50	55	71	73.6	91.7	97.1
5	Говь-Алтай	35	45	60	33.6	45.8	49.5
6	Говьсүмбэр	12	19	35	31.7	55.4	85.5
7	Дархан-Уул	576	490	578	287.6	242.9	266.3
8	Дорноговь	330	360	337	264.0	335.2	255.1
9	Дорнод	255	173	345	160.6	114.3	195.7
10	Дундговь	97	125	101	143.5	180.6	124.3
11	Завхан	27	11	35	24.5	9.7	28.1
12	Орхон	408	212	207	176.7	94.9	84.6
13	Өвөрхангай	167	164	167	84.0	83.3	74.6
14	Өмнөговь	477	419	580	378.9	299.9	380.5
15	Сүхбаатар	87	110	102	78.4	90.7	80.8
16	Сэлэнгэ	10	33	24	7.5	25.2	15.4
17	Төв	121	61	79	151.3	77.2	80.9
18	Увс	203	245	267	121.0	140.3	144.8
19	Ховд	12	44	36	6.6	23.3	17.4
20	Хөвсгөл	40	27	41	17.4	12.4	16.0
21	Хэнтий	77	68	86	59.3	52.8	59.0
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>3420</b>	<b>3029</b>	<b>3728</b>	<b>112.5</b>	<b>100.9</b>	<b>110.2</b>
23	Улаанбаатар	9648	9168	9714	274.1	267.3	259.9
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>13068</b>	<b>12197</b>	<b>13442</b>	<b>199.2</b>	<b>189.7</b>	<b>188.8</b>

Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 19 тохиолдол буюу 8.9 хувь нь төрөөгүй ба анх удаа үр хөндүүлсэн байна. Нийт үр хөндөлт хийлгэсэн эмэгтэйчүүдийн 168 тохиолдол 79.2 хувьд жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглүүлсэн.

Үр хөндөлт 2016-2023 он /улс, аймаг/

№	Он	Үр хөндөлтийн тоо	Улсын дундаж 1000 амьд төрөлтөд	Орхон аймаг 1000 амьд төрөлтөд
1	2016	773	234.2	297.5
2	2017	626	235.8	242.7
3	2018	263	204.0	95.6

4	2019	234	198.0	89.2
5	2020	150	191.7	58.7
6	2021	33	168.1	13.1
7	2022	408	199.2	178.4
8	2023	212	189.7	94.9

## НЯЛХАС БОЛОН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2023 оны жилийн эцсийн байдлаар тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн 21 тохиолдол бүртгэгдэж, амьд төрсөн 1000 хүүхдэд 9.4 ногдож байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд ноогдох тав хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 2.5 промилоор өссөн. Тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн 13 /61.9%/ эрэгтэй, 8 /3.8%/ эмэгтэй хүүхэд байна.

### Тав хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 2023 /үндсэн онош/

#### Үндсэн онош

K56.5	-	1	-	4.8%	Гэдэсний түгжрэлтэй наалданги [наалданц]
P07.0	-	1	-	4.8%	Хэт бага нинтэй төрөх
P21.0	-	1	-	4.8%	Төрөх үеийн хүнд бүтэлт
P22.0	-	2	-	9.5%	Нярайн амьсгал гачаалын хамшинж
P23.9	-	1	-	4.8%	Төрөлж пневмони, тодорхойгүй
P24.1	-	1	-	4.8%	Нярай ураг орчмын шингэн ба салиагаар хахах
P24.3	-	1	-	4.8%	Нярай хоол ба сүүгээр гүлфиснаас хахах
P25.1	-	1	-	4.8%	Перинаталь үед үүссэн пневмоторакс
P28.5	-	1	-	4.8%	Нярайн амьсгалын дутмагшил
P91.1	-	1	-	4.8%	Нярайн тархины ховдол тойронгийн олдмол
уяланхай					
Q20.1	-	1	-	4.8%	Баруун ховдол хоёр гарах амсартай байх
Q21.2	-	1	-	4.8%	Тосгуур-ховдол хоорондын таслаачийн гажиг
Q21.3	-	1	-	4.8%	Фаллогийн дөрвөл
Q39.1	-	1	-	4.8%	Мөгөөрсөн ба улаан хоолойн цорготой улаан
хоолойн битүүрэл					
Q89.7	-	1	-	4.8%	Өөр бүлэгт ангилаагүй төрөлх олон гажиг
W17	-	1	-	4.8%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих
W75	-	2	-	9.5%	Орон дотроо санамсаргүй амьсгал боогдох,
дарагдах					
W78	-	1	-	4.8%	Ходоод дахь зүйл амьсгалын зам таглах
X40	-	1	-	4.8%	Опиоид бус өвчин намдаах, халуун бууруулах ба хэрлэгийн эсрэг эмэнд санамсаргүй хордох, өртөх

Нийт дун = 21

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.1 промилл. Өмнөх оны мөн үеэс 3 тохиолдол буюу 1.6 промилоор өссөн. Улсын дунджаас 4.2 промилоор бага байна. Нялхсын эндэгдлийн 10 тохиолдол эрэгтэй, 8 тохиолдол эмэгтэй бүртгэгдсэн. Нялхсын эндэгдлийн 66.7 хувийг 0-28 хоногтой нярайн эндэгдэл эзэлж байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 55.5 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 22.2 хувь, осол гэмтэл, гадны шалтгаант 16.6 хувийг тус тус эзэлж байна.

Нялхсын эндэгдэл 2023, 1000 амьд төрөлтөд, аймгаар




Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нас, хүйсээр, 2018-2023 он


Үзүүлэлт	2018		2019		2020		2021		2022		2023	
	Орхон	Улс	Орхон	Улс	Орхон	Улс	Орхон	Улс	Орхон	Улс	Орхон	Улс
Перинаталь эндэгдлийн түвшин	8.3	8.3	8.3	11.9	8.3	8.3	8.3	11.9	8.2	10.8	8.0	10.4
1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	8.3	8.3	6.5	13.4	8.3	8.3	6.5	13.4	6.5	12.4	8.1	12.3
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	10.6	10.6	9.4	16.9	10.6	10.6	9.4	16.9	6.9	15.5	9.4	14.9

Перинаталь эндэгдлийн түвшин өмнөх оноос 0.2 промилоор буурсан. Улсын дунджаас 2.4 промилоор бага байна. Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 961 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58 тохиолдлоор буурсан байна.

Перинаталь эндэгдэл 2023, 1000 нийт төрөлтөд, аймгаар



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2023, 1000 амьд төрөлтөд, аймгаар



## ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн эрүүл мэндийн төв, Сумын эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Эрдэнэт сувилал, Эрдэнэт медиал зэрэг 167 байгууллагууд 2073 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.


Эрүүл мэндийн байгууллагын тоо 2016-2023 он

Эрүүл мэндийн байгууллагууд	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Эрүүл мэндийн газар	1	1	1	1	1	1	1	1
Өрхийн эрүүл мэндийн төв	8	8	8	8	8	8	8	8
Жаргалант сумын эрүүл мэндийн төв	1	1	1	1	1	1	1	1
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	1	1	1	1	1	1	1	1
Ортой хувийн эмнэлэг	11	12	12	14	13	13	12	12
Клиник хувийн	50	50	56	56	56	55	54	53
Эм ханган нийлүүлэх байгууллага	8	8	8	10	13	10	13	9
Хувийн эмийн сан	51	56	56	59	66	76	85	80
Эрдэнэт сувилал цогцолбор	1	1	1	1	1	1	1	1
Эрдэнэт медиал							1	1
Нийт	132	138	144	151	160	166	177	187

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын хэвтэн эмчлүүлэх, ашиглах орны дээд хязгаарыг 2023 онд нийт 1041 ороор баталж, БОЭТ 433, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд 463, Жаргалант сум 12, Эрдэнэт медиал 33, Эрдэнэт сувилал 100 ортойгоор үйл


ажиллагаа явуулж байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2016-2023 он



Хэвтэн эмчлүүлэх иргэдийн тоо сүүлийн 3 жилд огцом өссөн. Шалтгаанаар нь авч үзвэл зүрх судасны өвчлөл 10000 хүн амд 628, амьсгалын замын өвчлөл 560.4, уламжлалт оношоор хэвтэн эмчлүүлэгчид 548.6, хоол боловсруулах өвчлөлүүд 342.6 промилоор тэргүүлж байна. Шээс бэлгэсийн өвчлөлөөр хэвтэн эмчлүүлсэн иргэдийн тоо буурсан байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн тэргүүлэх өвчлөл 10000 хүн амд



### Орны үзүүлэлт 2021-2023

№	Эмнэлгийн нэр	Төсөвт орны тоо			Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо			Ор хоног		
		2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
1	Ачит	53	51	51	2560	2681	2612	17866	19360	19717
2	Бадархундага	51	53	51	2651	2924	2469	18460	20516	17071
3	Талын булаг	52	49	57	2388	1804	1915	16349	12481	13862
4	Их тавт	25	27	31	752	1083	1077	5676	7784	7451
5	Тайхар	55	49	51	2794	2784	2916	20778	18906	18997
6	Нейрон	22	24	18	686	886	764	5254	5900	5116
7	Эрхэсторгил	15	17	17	537	893	713	3311	5139	4064
8	Мөнхийн үйлс	25	22	24	874	1008	1139	5791	6914	7994
9	Очирувидас	48	50	58	1624	2181	1797	11519	15616	12522
10	Оюу	10	12	15	286	285	328	1887	1649	2037
11	Эрдэнэт медиал		38	33		461	1102		2230	5183
12	Баянөндөр	50	51	60	1841	1241	2012	14687	9009	14172
13	Шинэ эрин мед	25	20	30	308	1123	930	2293	8450	6870
14	БОЭТ	434	434	433	17920	18346	17773	123842	116629	120010
15	Сум	10	10	12	190	315	442	1368	2167	3085
16	Медипас	25	38		1283	279		6281	1317	
	<b>Нийт</b>	<b>900</b>	<b>907</b>	<b>941</b>	<b>36694</b>	<b>38294</b>	<b>37989</b>	<b>255362</b>	<b>254067</b>	<b>258151</b>

Аймгийн орны фонд ашиглалтын хувь 78, дундаж ор хоног 6.8, орны эргэлт 42.3, улсын дундаж орны фонд ашиглалт 66.1 хувьтай байна.

### Орны үзүүлэлт 2021-2023

№	Эмнэлгийн нэр	Дундаж ор хоног /1 өвчтөний хэвтэж эмчлүүлсэн хоног/			Орны эргэлт /эмнэлгийн 1 орон дээр хэвтэн эмчлүүлсэн хүний тоо/			Орны фонд ашиглалт /гужайн жилд 1 орыг ашигласан хоногийн тоо/			Орны фонд ашиглалтын хувь		
		2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
1	Ачит	7	7.2	7.5	48.3	52.6	51.2	337	380	386.6	92.4	104	105.9
2	Бадархундага	7	7	6.9	52	55.2	48.4	362	387	334.7	99.2	106	91.7
3	Талын булаг	6.8	6.9	7.2	45.9	36.8	33.6	314	255	243.2	86.1	69.8	66.6
4	Их тавт	7.5	7.2	6.9	30.1	40.1	34.7	227	288	240.4	62.2	79	65.9
5	Тайхар	7.4	6.8	6.5	50.8	56.8	57.2	378	386	372.5	104	106	102.1
6	Нейрон	7.7	6.7	6.7	31.2	36.9	42.4	239	246	284.2	65.4	67.4	77.9
7	Эрхэсторгил	6.2	5.8	5.7	35.8	52.5	41.9	221	302	239.1	60.5	82.8	65.5
8	Мөнхийн үйлс	6.6	6.9	7.0	35	45.8	47.5	232	314	333.1	63.5	86.1	91.3
9	Очирувидас	7.1	7.2	7.0	33.8	43.6	31.0	240	312	215.9	65.7	85.6	59.1
10	Оюу	6.6	5.8	6.2	28.6	23.8	21.9	189	137	135.8	51.7	37.6	37.2
11	Эрдэнэт медиал		4.8	4.7	0	12.1	33.4	0	58.7	157.1	0	32.2	43.0
12	Баянөндөр	8	7.3	7.0	36.8	24.3	33.5	294	177	236.2	80.5	48.4	64.7
13	Шинэ эрин мед	7.4	7.5	7.4	12.3	56.2	31.0	91.7	423	229.0	25.1	116	62.7
14	БОЭТ	6.9	6.4	6.8	41.3	42.3	41.0	285	269	277.2	78.2	73.6	75.9
15	Сум	7.2	6.9	7.0	19	31.5	36.8	137	217	257.1	37.5	59.4	70.4
16	Медипас	4.9	4.7		51.3	7.3		251	34.7		68.8	9.5	0.0

Дундаж ор хоног Ачит эмнэлгийн 7.5, Шинэ эрин мед 7.4, Талын булаг 7.2 хамгийн өндөр байгаа бол эмнэлгийн нэг орон дээр хэвтэн эмчлүүлсэн хүний тоо буюу орны эргэлтээр Тайхар 57.2, Ачит 51.2, Бадархундага 48.4-өөр тэргүүлж байна. Орны фонд ашиглалт Ачит 105.9, Тайхар 102.1 байгаа нь эрүүл мэндийн газраас баталсан орны дээд хязгаарыг хэтрүүлэн хэвтэн эмчилсэн байна.

## ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм. Монгол Улсад өрх, сумын эрүүл мэндийн төвүүд нь харьяаллын хүн амд чиг үүргийн дагуу тав хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалт, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, эх хүүхдийн гэрийн эргэлт зэрэг 8 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

2023 оны байдлаар 8 өрхийн эрүүл мэндийн төв Баян-Өндөр сумын 102814 мянган хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Найман өрхийн эрүүл мэндийн төвд их эмч 57, сувилагч 67 болон нийт 185 албан хаагч хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2023 оны байдлаар аймгийн хэмжээний нийт үзлэгийн 47.8 хувийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдэж, нэг эмчид ногдох үзлэгийн тоо 6270 буюу нэг өдөрт 285 хүн тусламж үйлчилгээ авсан үзүүлэлттэй байна. Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэг 50.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс (1.4) хувиар, гэрийн идэвхтэй үзлэг 31.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс (2.3) хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

*Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд 2016-2022 он*

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Их эмчийн тоо	43	48	51	51	58	49	56	57
Сувилагчийн тоо	42	43	49	49	59	60	64	67
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	315051	302148	292072	324340	358780	394058	353181	340716
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	45.7	45.9	49.7	48.1	45.8	50.9	49	171771
Нэг иргэнийн жилд үзүүлсэн тоо	2.9	3.1	3	3.3	3.4	3.8	3.4	3.3
Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо	7327	6295	5727	6360	6185	8042	7207	5977
Жирэмсний эрт үеийн хяналт	90.8	89.9	91	93.9	93.1	96.8	96.4	96.5



## ӨРХ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГ

2023 оны байдлаар аймгийн хэмжээнд артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насны нийт 52703 буюу хамрагдвал зохих хүн амын 99.3 хувийг эзэлж, өмнөх оноос (36.5) хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.9 хувь нь онош батлагдсан. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 40-дээш насны нийт 29409 буюу хамрагдвал зохих хүн амын 117.7 хувийг эзэлж, өмнөх оноос (39.5) хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувь онош батлагдсан байна.

### 2023 ОНЫ БАЙДЛААР



№	Эмнэлгийн нэр	АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ ЭРТ ИЛРҮҮЛЭГ						ЧИХРИЙН ШИЖИН ХАМ ШИЖ - 2 ЭРТ ИЛРҮҮЛЭГ							
		Хамрагдсан хүний тоо		Оношлогдсон АГ		Хамрагдалтын хувь		Хамрагдсан хүний тоо		Оношлогдсон ЧШ		Хамрагдалтын хувь		Өмнөх оны мөн үеэс	
		2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023		
1	Үйлс Бадрах	3535	3759	109	8	36.7	59.2	+22.5	2489	2137	18	8	59.8	71.7	+20.9
2	Нийцал	6289	6316	101	113	95.0	113.8	+28.8	2850	4082		13	103.7	119.1	+15.4
3	Мөнхийн гэгээ	4273	4465	254	122	72.7	112.9	+40.2	2381	2388	23	55	85.9	105.9	+20.3
4	Энхжилтэндэвчлэл	5835	5398	99	24	89.4	110.3	+20.9	3665	2480	1	8	82.6	106.9	+14.3
5	Аюуны оч	5800	9344	7	30	45.6	83.4	+48.4	4486	5971	6	21	83.4	117.1	+51.7
6	Мандуцан	2529	6957	21	37	21.3	74.1	+52.8	1822	3992	4	6	48.4	114.4	+66.0
7	Учралтбаяр	3550	6597	15	16	41.4	96.8	+55.4	1882	2280	4		52.7	106.0	+53.3
8	Мөнх сундрал	5194	5044	132	105	84.1	116.5	+32.0	2047	2292			63.4	99.0	+33.6
9	Жаргалант	1361	1732	4	15	55.3	96.8	+41.5	797	1097	3	7	38.8	100.3	+55.5
	Бүгд	43118	49612	742	470	62.8	93.5	+30.7	26522	26696	59	118	78.2	106.9	+28.6
	<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>43118</b>	<b>52703</b>	<b>742</b>	<b>470</b>	<b>62.8</b>	<b>99.3</b>	<b>+36.8</b>	<b>26522</b>	<b>29409</b>	<b>59</b>	<b>118</b>	<b>78.2</b>	<b>117.7</b>	<b>+39.5</b>

## СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумын эрүүл мэндийн төвүүдийг нь аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих

хугацаанаас хамааран А, Б, В зэрэглэлд ангилна. Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь В зэрэглэлд багтдаг ба нийт 22 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 12 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

*Сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд 2016- 2023 он*

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Их эмчийн тоо	4	4	3	5	4	4	4	4
Сувилагчийн тоо	5	5	5	5	4	5	5	4
Эмнэлгийн орны тоо	10	10	10	10	10	10	10	12
Дундаж ор хоног	7.5	7.3	7.3	6.8	6.9	7.2	6.8	6.9
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	8773	12906	10528	11246	10702	20021	10195	10404
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	24.5	39.6	30	39.9	30.1	59.4	42	45.2
Нэг иргэнийн жилд үзүүлсэн тоо	2.3	3.3	2.7	3	3.1	5.8	3	3
Жирэмсний эрт үеийн хяналт	89.1	100	97.1	93.5	94.9	82.3	100	94
Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/	0	0	0	0	0	0	0	0
Нялхасын эндэгдэл	0	1	0	0	1	0	1	2

2023 оны байдлаар аймгийн нийт орны 1.1 хувь нь сумын эрүүл мэндийн төвийн эмнэлэгт ногдож байна.

## БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл 131 их эмч, 182 сувилагч, 78 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 537 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нийт орны 41.6 хувь нь ногдож байна.

БОЭТ-д 2023 онд 17864 хүн хэвтэн эмчлүүлсэн ба нийт эмнэлэгт хэвтэгсдийн 46.8 хувийг эзэлж байна.

*БОЭТ-ийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд 2016- 2023 он*

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Их эмчийн тоо	111	107	115	123	119	117	122	131
Сувилагчийн тоо	202	205	194	199	194	195	183	182
Эмнэлгийн орны тоо	434	434	434	434	434	434	434	433
Дундаж ор хоног	7.4	7.0	6.7	6.8	6.6	6.9	6.3	6.7
Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо	15668	14466	15257	16934	13587	17920	18346	17864
Хоног болоогүй нас баралтын хувь	47.3	35.0	39.6	32.5	40.2	29.8	37.9	34.3

Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	137396	143778	157316	172095	153569	135037	173467	195006
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	25.0	24.6	28.7	28.0	25.2	19.9	18.9	15.4
Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/	0	0	0	0	0	39.9	0	0
Нялхасын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/	12.6	3.5	4.7	6.1	6.6	10.8	4.3	5.8
Додд шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	15.8	15.7	16.2	13.6	18.4	14.2	17.6	19.4

2023 онд эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь өмнөх оноос 3.6 хувь амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 3.5 хувиар буурсан байна.

## ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ


2023 оны байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 47.9 хувийг эмийн сан, 31.7 хувийг хувийн клиник, 5.4 хувийг эм ханган нийлүүлэх байгууллага, 7.2 хувийг ортой эмнэлэг эзэлж байна. Эдгээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 907 ажиллагчид ажиллаж байгаагаас нийт ажиллагчдын 25.1 хувийг хувийн клиникт, 36.6 хувийг ортой хувийн эмнэлэгт, 33.2 хувийг эмийн сангуудад, 5.1 хувь нь эм ханган нийлүүлэх байгууллагад ажиллаж байна. Хувийн хэвшлийн эмнэлэгт 2023 онд 18672 хүн хэвтэн эмчлүүлж, дундаж ор хоног 6.9 байна.

*Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд 2016-2023 он*

	2016	2017	2018	2019	2020 он	2021 он	2022	2023
Ортой эмнэлгийн тоо	11	12	12	12	13	13	12	12
